МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 28 өдөр Дугаар А/126 Улаанбаатар хот

Компанийн дүрмийг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай” 193 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.“Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн дүрмийг холбогдох хууль, журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Э.Энхзориг)-д үүрэг болгосугай .

3.Зам, тээврийн сайдын 2024 оны "Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" А/290 дүгээр тушаалын нэг, хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Б.ДЭЛГЭРСАЙХАН

СБТ-Э: 257890

142630314

Зам, тээврийн сайдын 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/126 дугаар тушаалын хавсралт

"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмийн зорилго нь "Иргэний нисэхийн үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн байдал, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, чиг үүргийг тогтоож, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. "Иргэний нисэхийн үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид "Компани" гэх) нь Монгол Улсын агаарын навигацийн үйлчилгээтэй холбоотой хураамжийн орлогыг хууль тогтоомжид нийцүүлэн төвлөрүүлэх, түүний ил тод, үр ашигтай, оновчтой зарцуулалтыг хангах, нислэгийн хөдөлгөөний удирдлагын болон агаарын навигацийн үйлчилгээний техник, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх, олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэх, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, мэргэжлийн ажилтнуудыг дотоод, гадаадын сургалт, дадлага, мэргэшүүлэх хөтөлбөрт хамруулах, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, салбарын шилдэг туршлагыг нэвтрүүлэх, өөрт олгогдсон төрийн өмчийг хамгаалах, хадгалах, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, эд хөрөнгийн менежментийг сайжруулах замаар үнэ цэнийг өсгөх, тогтвортой ашиглалтыг хангах, өөрийгөө санхүүжүүлэх зарчмыг баримтлан үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, цаашдын хөгжил, хөрөнгө оруулалтыг дэмжих санхүүгийн чадавхыг бүрдүүлэх зарчмаар ажиллана.

1.3. Компани нь Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц, түүний хавсралтууд, Иргэний нисэхийн тухай хууль, Компанийн тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Иргэний нисэхийн багц дүрэм, агаарын тээврийн гэрээ, хэлэлцээр, эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас тэдгээрт нийцүүлэн гаргасан тогтоол, тушаал, шийдвэр болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.4. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, арилжааны банканд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээдэг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, санхүүгийн тайлан гаргадаг, ашгийн төлөө хуулийн этгээд мөн.

1.5. Компани нь 100 (нэг зуун) хувь төрийн өмчит бөгөөд 1 (нэг) хувьцаа эзэмшигчтэй хуулийн этгээд байна.

1.6. Компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага байна.

Хоёр. Компанийн оноосон нэр, байршил

2.1. Компанийн оноосон нэр нь "Иргэний нисэхийн үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, товчилсон нэр нь "ИНҮТ" ТӨХХК, англиар "National Civil Aviation Center" state-owned limited liability company, товчилсон нэр нь "NCAC" SO LLC болно.

2.2. Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 21 хороо, Буянт-Ухаа, "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК.

2.3. Хаягийн өөрчлөлтийг компанийн гүйцэтгэх удирдлага тухай бүр Улсын бүртгэлд бүртгүүлнэ.

Гурав. Компанийн бэлгэдэл, тэмдэг

3.1. Компани нь өөрийн бэлгэдэлтэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

3.2. Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээждэг салбар алба, нэгж, албан тушаалтнууд үйл ажиллагаандаа тэмдэг хэрэглэж болно.

3.3. Компанийн бэлгэдэл, албан бичгийн хэвлэмэл хуудасны загварыг Төлөөлөн удирдах зөвлөл баталж, Оюуны өмчийн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн компани эдэлнэ.

3.4. Компанийн тамга, тэмдгийг компанийн гүйцэтгэх удирдлага, эсхүл түүнээс итгэмжлэн хариуцуулсан ажилтан түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

Дөрөв. Компанийн үйл ажиллагааны зарчим

4.1. Компани нь өөрчлөн байгуулах, татан буулгах тухай Засгийн газрын шийдвэр гаснаас бусад тохиолдолд үйл ажиллагаагаа хугацаагүй эрхлэн явуулна.

4.2. Компани нь иргэний нисэхийн салбарт Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц, түүний хавсралтуудын стандарт, шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлэх бөгөөд мэргэжлийн, бие даасан үйл ажиллагаагаараа дамжуулан улс орны нийгэм, эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлнэ.

4.3. Компани олон улсын стандартад нийцсэн эрсдэлийн удирдлага болон эрсдэлээс сэргийлэх арга хэрэгсэлтэй байна.

4.4. Компани нь санхүүгийн хувьд үр ашигтай, нисэхийн аюулгүй байдлыг бүрэн хангахуйц, хэмнэлттэй, нээлттэй, ил тод, хяналттай байхаас гадна улс төрийн нөлөөллөөс ангид байна.

4.5. Компанийн хүний нөөцийн бодлого төлөвлөлтөд төрийн албаны чадахуйн зарчмыг баримтлах ба хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах, мэдлэг, ур чадварыг хадгалах, тасралтгүй хөгжүүлэх, чадавхжуулахад чиглэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26/11/126

4.6. Компани нь үйл ажиллагаагаа эдийн засгийн хувьд үр ашигтай, тогтвортой байдлыг хангах, өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх зарчимд тулгуурлан явуулж, олон улсын гэрээ, конвенц, стандарт, зөвлөмжид нийцсэн агаарын навигацийн болон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, олон улсын түвшинд өрсөлдөхүйц үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, туршлага солилцох, дэвшилтэт техник, технологи, инновацийг нэвтрүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, хамтын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, санхүүжилтийн олон эх үүсвэрийг бүрдүүлэх замаар компанийн урт хугацааны тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд анхаарч ажиллана.

Тав. Компанийн үндсэн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

5.1. Компанийн үндсэн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт болон агаарын зайд нисэхийн аюулгүй байдлыг хангасан, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, үр ашигтай, тогтвортой, хүртээмжтэй орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан нисэхийн ба нисэхийн бус үйлчилгээ эрхлэгч олон улсад тэргүүлэгч байгууллага байна.

5.2. Компани нь үйл ажиллагааны дараах стратегийн зорилтыг баримтлан ажиллана:

5.2.1. Нисэхийн аюулгүй байдлыг хангах, чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх;

5.2.2. Агаарын навигацийн үйлчилгээ, нисэх буудлын үйлчилгээ, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

5.2.3. Удирдлага зохион байгуулалтаар хангах, компанийн дотоод үйл ажиллагааг зохион байгуулах, төлөвлөлт, гүйцэтгэлийг хангуулах, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу хөтлөн явуулах, гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

5.2.4. Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, компанийн “Хүн төвтэй хөгжлийн бодлого” хэрэгжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, бүтээмжийг сайжруулах, ажилтан руу чиглэсэн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, ажилтны эрүүл мэндийг сахин хамгаалах, биеийн тамираар хичээллэх боломжоор хангах;

5.2.5. Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн үйл ажиллагааг нэгдсэн бодлого, чиглэл, удирдлагаар хангаж, орлогыг нэмэгдүүлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөх, гүйцэтгэлийг хангах, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

5.2.6. Компанийн хөгжлийн бодлого, түүнд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, компанийн орлогыг нэмэгдүүлэх, шинэ орлогын

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн ... албаны
Дэлгэн 26 11/26 хуудас

эх үүсвэр, бизнесийг хөгжүүлэх, судалгаа шинжилгээ хийх, барилга, байгууламжуудын бүртгэл, судалгааг хөтөлж, ашиглалтын байдалд хяналт тавих;

5.2.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх,хэрэгжилт, үр дүнд хяналт тавих;

5.2.8. Иргэний нисэхийн чиглэлээр олон улсад хэрэгжиж буй дэвшилтэт техник, технологи, инновацыг судалж үйл ажиллагаанд нэвтрүүлэх, мэдээлэл, техник технологийн системийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, оролцогч талуудын харилцан үр ашигтай, бүтээлч хамтын ажиллагааг хөгжүүлэх.

5.3. Компани нь дор дурдсан үндсэн чиглэлийн үйл ажиллагааг эрхэлнэ:

5.3.1. Монгол Улсын олон улсын иргэний нисэхийн гэрээ, конвенцоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх;

5.3.2. Иргэний нисэхийн салбарын бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах;

5.3.3. Агаарын навигацийн үйлчилгээ үзүүлэх:

5.3.3.1. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ;

5.3.3.2. Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент;

5.3.3.3. Агаарын зайн менежмент;

5.3.3.4. Нисэхийн мэдээллийн үйлчилгээ;

5.3.3.5. Нисэхийн цаг уурын үйлчилгээ;

5.3.3.6. Холбоо, навигаци, ажиглалтын үйлчилгээ;

5.3.3.7. Эрэн хайх, авран туслах мэдээллийн үйлчилгээ;

5.3.3.8. Нислэгийн журам зохиох үйлчилгээ.

5.3.4. Аэродромын үйлчилгээ үзүүлэх:

5.3.4.1. Аэродромын үйлчилгээ;

5.3.4.2. Гал унтраах авран хамгаалах;

5.3.4.3. Гэрэл суултын систем;

5.3.4.4. Газрын тусгай тоног төхөөрөмжийн үйлчилгээ;

5.3.4.5. Ачаа шуудан тээврийн үйлчилгээ;

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

5.3.4.6. Тусгай тоног төхөөрөмж, машин механизм.

5.3.5. Нисэх буудлын үйлчилгээг үзүүлэх:

5.3.5.1. Зорчигч үйлчилгээ;

5.3.5.2. Шатахуун, хангамж, хадгалалтын үйлчилгээ;

5.3.5.3. Терминал үйлчилгээ.

5.3.6. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх;

5.3.7. Оношилгоо, хэмжил зүйн үйлчилгээ;

5.3.8. Шалгалтын нислэгийн үйлчилгээ;

5.3.9. Нисэхийн сургалт, судалгааны үйлчилгээ;

5.3.10. Үйл ажиллагааг дэмжих бусад үйлчилгээ:

5.3.10.1. Мэдээллийн технологи, программ хөгжүүлэлт;

5.3.10.2. Биеийн тамир, бялдаржуулах, сэргээн засах сувилал;

5.3.10.3. Барилга байгууламжийн засвар үйлчилгээ;

5.3.10.4. Тусгай хэрэгцээт тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ /аэродром/;

5.3.10.5. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт /аэродром, холбоо навигацийн тоног төхөөрөмж/;

5.3.10.6. Аэродром орчмын аюулгүй бүсийн газрын менежментийг хэрэгжүүлэх.

5.4. Орлого нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бусад хуулиар хориглоогүй үйл ажиллагаа явуулна.

5.5. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулахдаа эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

Зургаа. Компанийн өөрийн эд хөрөнгө, хувьцаа

6.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанаас бүрдэх бөгөөд нэг бүр нь 10,000 (арван мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000 (нэг мянга) ширхэг, нийт 10,000,000 (арван сая) төгрөгийн үнэтэй энгийн хувьцаатай байна.

6.2. Компани нь хувьцаа нэмж гаргах замаар компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж болох бөгөөд хувьцааны төрөл, тоо, нэрлэсэн үнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн санал болгосноор Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 АЛ26

6.3. Компанийн хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

6.4. Компанийн хөрөнгө нь 100 (нэг зуун) хувь төрийн өмчид байгааг харгалзан компанийн хувьцаа нь Хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гарах хүртэл арилжаалагдахгүй байна

Долоо. Компанийн удирдлага

7.1. Компанийн удирдлага нь дараах бүтэцтэй байна:

7.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал (хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч);

7.1.2. Төлөөлөн удирдах зөвлөл;

7.1.3. Гүйцэтгэх удирдлага.

Найм. Хувьцаа эзэмшигчдийн хурал

8.1. Монгол Улсын Засгийн газраас эрх олгосноор компанийн хувьцаа эзэмшигчийн хурлын бүрэн эрхийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хэрэгжүүлнэ.

8.2. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

8.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дуусснаас хойш 4 (дөрвөн) сарын дотор хуралдуулна.

8.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

8.4.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх, тэдний цалин, урамшууллын хэмжээг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

8.4.2. Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах;

8.4.3. Компанийн гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх болон бусад асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж өгөх;

8.4.4. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

8.4.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн жилийн ажлын тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А/126

8.4.6. Компанийн тухай хууль болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудал.

8.4.7. Хууль, тогтоомжид заасан бусад

8.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хэлэлцэх асуудлын онцлогоос хамаарч 30 хоногийн дотор хуралдуулна.

8.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн асуудлаар тогтоол (тушаал) гаргах бөгөөд хэлэлцсэн асуудал, хурлын явцын талаар тэмдэглэл хөтөлнө.

Ес. Төлөөлөн удирдах зөвлөл

9.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь энэ дүрэм, хууль болон Засгийн газраас баталсан журамд заасан ур чадвар, мэргэшил, боловсрол, ажлын туршлага зэрэг шаардлагыг хангасан байна.

9.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 (ес) гишүүнтэй, түүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна. Гишүүдийн бүрэлдэхүүнд иргэний нисэхийн чиглэлээр мэргэшсэн хүн заавал багтсан байна.

9.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх асуудлыг Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

9.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жилээс хэтрэхгүй байх бөгөөд ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны тайланг үнэлж нэг удаа улируулан томилж болно.

9.5. ТУЗ-ийн дарга, гишүүд тогтмол цалин, хөлс авах ба үндсэн цалин нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороонд ажилласан байдлыг харгалзан нэмэгдэл олгож болно.

9.6. Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс өгсөн удирдамжаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.6.1. Компанийн тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

9.6.2. Бизнесийн тодорхой төсөл, томоохон хөрөнгө оруулалтын арга хэмжээ санхүүжүүлэх, хэрэгжүүлэх;

9.6.3. Зээл авах, хувьцаа, үнэт цаас гаргахтай холбогдсон шийдвэр гаргах;

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
20 11/26

9.6.4. Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх, эрсдэлийг бууруулах, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх;

9.6.5. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг тодорхойлох;

9.6.6. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс өгсөн удирдамжийн дагуу баталсан үйл ажиллагааны төсөвт үндэслэн компанийн бизнес төлөвлөгөө, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах;

9.6.7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

9.6.8. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс өгсөн удирдамжийн дагуу компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлах;

9.6.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах;

9.6.10. Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;

9.6.11. Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал, урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах;

9.6.12. Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, компанийн тайлан, тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;

9.6.13. Компаниас хуваарилах ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журам, хугацааг тодорхойлох;

9.6.14. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журам, бусад холбогдох дүрэм, журмуудыг батлах;

9.6.15. Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;

9.6.16. Хууль тогтоомжийн дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

9.6.17. Компанийг өөрчлөн байгуулах талаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

9.6.18. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарахгүй бусад асуудлыг шийдвэрлэх;

9.6.19. Компанийн үйл ажиллагаа, тухайн жилийн үйл ажиллагааны төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэх;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 11/126

9.6.20. Компанийн шинээр худалдаж авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгөтэй холбогдох асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

9.6.21. Өр авлага барагдуулах талаар чиглэл өгөх, эргэн төлөлтийг бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээр барагдуулах талаар хэлэлцэх;

9.6.22. Компанийн тухай хууль, энэ дүрэмд тухайлан заасан бусад.

9.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл нь хуралдаан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал нийт гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор хүчин төгөлдөр болно.

9.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн олонхын саналаар сонгоно.

9.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйлажиллагааг зохион байгуулах, хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүргийг хүлээнэ.

9.10. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан тогтоол, тэмдэглэлд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдгийг дарснаар хүчин төгөлдөр болно.

9.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын түр эзгүйд түүний үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын томилсон, эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон гишүүн гүйцэтгэнэ.

9.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр нь хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхын саналаар хүчин төгөлдөр болно.

9.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зарлах, хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудлыг хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох,Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын эрх болон бусад холбогдох асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

9.14. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас томилно. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасны дагуу ажиллах бөгөөд шаардлагатай бол нэмэлт үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгаж болно.

9.15. Төлөөлөн удирдах зөвлөл нь жилд нэгээс доошгүй удаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнана.

9.16. Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэрийг удирдлага болгоно.

9.17. Энэ дүрмээр болон хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхээр тогтоогоогүй Төлөөлөн удирдах зөвлөл, түүний үйл ажиллагаатай холбоотой

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 11/126

аливаа асуудлыг Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

Арав. Гүйцэтгэх удирдлага

10.1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх удирдлага нь компанийн Гүйцэтгэх захирал байна.

10.2. Гүйцэтгэх захирлыг Төлөөлөн удирдах зөвлөл холбогдох журамд заасны дагуу томилж, чөлөөлнө.

10.3. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

10.4. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

10.5. Гүйцэтгэх захирал нь санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, газрын дарга болон түүнээс дээш албан тушаалтныг томилох, чөлөөлөх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.

10.6. Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна:

10.6.1. Нисэх буудал, агаарын тээврийн менежмент, иргэний нисэхийн нисгэгч, нислэгийн удирдагч, нисэхийн холбоо, навигаци, аэродром, агаарын хөлгийн инженер, бизнесийн удирдлага, эрх зүй, эдийн засаг болон санхүүгийн аль нэг чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх;

10.6.2. Иргэний нисэхийн салбарт 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан туршлагатай байх;

10.6.3. Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын албан ёсны аль нэг гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй байх;

10.6.4. Зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

10.6.5. Ял шийтгэлгүй байх;

10.6.6. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

10.7. Гүйцэтгэх захирал нь хуульд заасан зөвлөл, хороодыг дэргэдээ байгуулж болно. Зөвлөл болон хороодын ажиллах журмыг Гүйцэтгэх захирал батална.

10.8. Гүйцэтгэх захирал дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ:

10.8.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнан дүгнүүлэх;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид Төрийн ... Бичгийн
Дарга ... албаны тушаал гүйцэтгэгч
26 11/26

10.8.2. Компанийн мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг хуульд заасан хугацаанд гаргаж, холбогдох этгээдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах;

10.8.3. Компанийн үйл ажиллагаа, тухайн жилийн үйл ажиллагааны төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах;

10.8.4. Компанийн бизнесийн төлөвлөгөөний төслийг батлагдсан төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулах;

10.8.5. Энэ дүрэм болон холбогдох хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, стандарт, норм, норматив, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

10.8.6. Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

10.8.7. Компанийн эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан компанийг удирдах;

10.8.8. Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;

10.8.9. Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан удирдлага, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан ажилтныг томилох, хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх, ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлэх;

10.8.10. Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;

10.8.11. Компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргах, биелэлтийг хангах;

10.8.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрлийн дагуу зарим эрх, үүргээ итгэмжлэлийн үндсэн дээр компанийн холбогдох эрх бүхий албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

10.8.13. Зохицуулалтгүй үйлчилгээний хураамж, үнэ тарифыг тогтоох.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Тэрбин нарыгаа бичгийн
дарын 26 ОНЫ 11/126 дугаар тушаал

Арван нэг. Компанийн эрх бүхий албан тушаалтан

11.1. Компани нь дараах эрх бүхий албан тушаалтнуудаас бүрдэнэ. Үүнд:

11.1.1. Төлөөлөн удирдах зөвлөл;

11.1.2. Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн;

11.1.3. Гүйцэтгэх захирал;

11.1.4. Захиргаа, хууль эрх зүйн нэгжийн дарга;

11.1.5. Санхүүгийн нэгжийн дарга;

11.1.6. Ерөнхий нягтлан бодогч;

11.1.7. Тооцооны нягтлан бодогч;

11.1.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга;

11.1.9. Үйлдвэрлэлийн нэгжийн дарга.

11.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль болон бусад хууль, дүрэм, журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

11.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан үүрэг, хариуцлага хүлээнэ.

Арван хоёр. Компанийн хяналтын тогтолцоо

12.1. Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:

12.1.1. Өмчлөгчийн хяналт;

12.1.2. Дотоод хяналт;

12.1.3. Хөндлөнгийн аудит.

12.2. Өмчлөгчийн хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо хэрэгжүүлнэ.

12.3. Аудитын хороо 3 гишүүнтэй байх бөгөөд гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөл томилно.

12.4. Аудитын хорооны дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.

12.5. Компанийн Аудитын хорооны ажиллах журам, Дотоод хяналтын журмыг тус тус Төлөөлөн удирдах зөвлөл батална.

12.6. Аудитын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна:

12.6.1. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэх, дотоод хяналтын

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ ЭХ ХУВЬ 26 А/126

болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

12.6.2. Шаардлагатай тохиолдолд дотоод хяналтын багийг томилох, ажлын төлөвлөгөөг батлах;

12.6.3. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт гаргах;

12.6.4. Компанийн дүрэмд заасан болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

12.7. Аудитын хороо нь компанийн дүрэм, Хувьцаа эзэмшигчийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган, үйл ажиллагаагаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

12.8. Аудитын хороо нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгахдаа энэ дүрэм болон холбогдох хуулиар олгогдсон эрхийг эдэлнэ.

12.9. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих чиг үүргийг дотоод хяналт хариуцсан нэгж, эсхүл ажилтан хэрэгжүүлнэ.

12.10. Дотоод хяналт хариуцсан нэгж, эсхүл ажилтан нь компанийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж, гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, энэ дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолд нийцэж байгаа эсэхийг хангаж ажиллана.

12.11. Дотоод хяналт хариуцсан нэгж, эсхүл ажилтан нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг Гүйцэтгэх захиралд өгч, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.

12.12. Компанийн хөндлөнгийн аудитыг Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороо сонгож, түүнтэй гэрээ байгуулна.

12.13. Хөндлөнгийн аудитын тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргана.

Арван гурав. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл

13.1. Их хэмжээний хэлцэл гэж тухайн хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 87, 88 дугаар зүйлд заасны дагуу хийнэ.

13.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийж байгаа аливаа хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 89, 91, 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 11/126

13.3. Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн энэ дүрмийн 13.1, 13.2-т заасан хэлцлийн талаарх мэдээллийг нийтэд (компани нь өөрийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан хэвлэл мэдээллийн хэрэгслээр) мэдээлэх үүрэгтэй.

Арван дөрөв. Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлан

14.1. Компани нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал хариуцна.

14.2. Компанийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэжлийн, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч байна.

14.3. Компани нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй байна.

14.4. Компани нь хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргуулсны дараа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу жилийн санхүүгийн тайлан, ашиг ба алдагдлын тайлангаа компанийн Хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл болон бусад эрх бүхий байгууллагад танилцуулна.

14.5. Компанийн санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусна.

Арван тав. Компанийн санхүүжилт болон санхүү, үйл ажиллагааны тайлан

15.1. Компани Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу анхан шатны нягтлан бодох бүртгэл хөтөлж улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.

15.2. Компани санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг томилон ажиллуулж болно.

15.3. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайланг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

15.4. Компани нь энэхүү дүрэмд заасан үйл ажиллагааны орлогоор санхүүжих ба хөрөнгө оруулалт, санхүүгийн захиран зарцуулалт, төлөвлөлт, хөрөнгийн удирдлагын талаар аливаа шийдвэр гаргахдаа эдийн засаг, санхүүгийн үр өгөөж, тооцоо, судалгаанд суурилсан байна.

15.5. Компани нь Иргэний нисэхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т зааснаар “Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлого нь агаарын навигацийн үйлчилгээг аюулгүй, тасралтгүй үзүүлэх, Конвенцын хавсралтын стандартын суурь түвшнийг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах хэмжээгээр улсын төсвөөс санхүүжиж болно”.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А/126

15.6. Компани нь хуулиар хязгаарлаагүй хэлбэрээр төсөл, төр, хувийн хэвшлийн түншлэл, зээл, тусламж, хандив зэрэг хэлбэрээр санхүүжилт татаж болох ба энэ тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан журмыг баримтална.

Арван зургаа. Компанийн баримт бичгийн хадгалалт

16.1. Компани нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу баримт бичгийг хадгалах үүрэгтэй.

16.2. Компани нь баримт бичгийг удирдлагын байрлаж байгаа газар буюу улсын бүртгэлд бүртгүүлсэн газарт хадгална.

16.3. Компани нь өөрийн дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг өөрийн архивд хадгална. Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийг хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтын дагуу баримт бичгийг хадгалах бөгөөд хугацаа дууссаны дараа улсын архивд шилжүүлнэ.

16.4. Компанийн талаарх мэдээлэл, компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээртэй холбогдох мэдээлэл авах асуудлыг Компанийн тухай хуулийн 98, 99 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

Арван долоо. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах

17.1. Компанийг Иргэний хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулж, татан буулгана.

17.2. Татан буулгах комисс томилогдсоноор компанийн Гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж, эрх нь татан буулгах комисст шилжинэ.

Арван найм. Компани нь салбар, төлөөлөгчийн газар

18.1. Компанийн салбар, төлөөлөгчийн газартай байж болох ба тэдгээр нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй.

18.2. Компанийн салбар, төлөөлөгчийн газрыг Төлөөлөн удирдах зөвлөл байгуулж, компаниас батална журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

18.3. Салбар, төлөөлөгчийн газар нь түүнийг байгуулсан компаниас баталсан орлогын төлөвлөгөөний дагуу орлого төвлөрүүлэх үүргийг хүлээнэ.

18.4. Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь үйл ажиллагаагаа түүнийг байгуулсан компанийн нэрийн өмнөөс явуулна.

18.5. Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь албан ёсны хэвлэмэл хуудас, салбар төлөөлөгчийн газрын тэмдэг хэрэглэнэ.

Арван ес. Бусад

19.1. Энэ дүрэмд тусгагдаагүй асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 A/126

19.2. Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч батлана.

19.3. Энэ дүрэм болон түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
даргын 26 А/126 дугаар тушаал